

4-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ.

Сурагчийн нэр .....

А Хувилбар

НИЙТ ОНОО 24

2024.06.03

Ухаарал

Өвөөгийнх голоос дандаа хол буудаг байсан бөгөөд голд ойр буудаг айлуудад ерөнхийдөө дургүй талдаа. Би зун өвөөгийнхөө очиж амардаг. Өнгөрсөн зун намайг өвөөгийнх очиход аавын төрсөн дүүгийн хүү Амараа хотоос ирсэн байв. Би үеэлтэйгээ зуны зугаатай өдрүүдийг хөгжилтэй сайхан өнгөрөөсөн билээ. Амараа бид хоёр хонинд ээлжилж явна. Гэрт үлдсэн нь эмээд тусалдаг байлаа.

Амараа нэг удаа усанд явахдаа эмээгийн хонь саадаг хувинг голын усанд угааж цэвэрлээд, ус авчирсан байв. Үдийн хойно хонио ус руу тууж явахад Амараа миний өмнөөс гүйж ирээд: “Би эмээ өвөө хоёрыгоо гомдоож орхилоо. Одоо яах вэ?” гэлээ. Би юу болсныг Амараагаас сонсоод “Голд цагаа оруулж болохгүй. Хувцас хунараа голын усанд угааж болохгүй. Усыг хайрлах хэрэгтэй” гэсэн эмээ, өвөөгийн сургаалыг Амараад хэлж өгөөгүйдээ өөрийгөө зэмлэж билээ.

1. Эхэд юуны тухай өгүүлсэн вэ?

А. Амараагийн тухай    Б. Зуны улирал    В. Гол, усыг бохирдуулж болохгүй    Г. Хүүхдийн амралтын тухай

2. Амараа хүү ямар буруу үйлдэл хийсэн бэ?

А. Эмээ өвөөдөө туслаагүй

Б. Амралтаараа эмээ, өвөөдөө очоогүй

В. Ээлжинд хонинд яваагүй

Г. Хонь саадаг хувинг голын усанд угааж цэвэрлэсэн.

3. Уриалсан өнгө аястай өгүүлбэрийг сонгоорой.

А. Хүүхдүүд усаа хайрладаг.

Б. Хүүхэд бүр усаа хайрласан.

В. Та усаа хайрласан уу?

Г. Хүүхдүүд ээ! Усаа хайрлацгаая

4. “орхилоо” гэдэг үгийн балархай эгшигтэй ижил үүргээр бичигдсэн үгийг олоорой.

А. Хариул

Б. Чийдэн

В. Салхилав.

Г. Багшил

5. Цэгийн оронд тохирох үгийг сонгон бичиж, өгүүлбэрийг гүйцээгээрэй. **Эмээ өвөөгийн үгийг .....**

А. Сонсёо

Б. Сонсоё

В. Сонсьё

Г. сонсьё

6. Өвөө нь голд ойр буудаг айлуудад яагаад дургүй байдаг вэ?

А. Өвөөгийнх голд ойрхон бууж чадаагүй учир

Б. Ан амьтанд хайртай учир

В. Гол уснаас айдаг учир

Г. Гол усаа хайрлан хамгаалдаг учир

7. “Аавын төрсөн дүүгийн хүү” - тохирох нэрийг зөв сонгоорой.

А. Зээ

Б. Үеэл

В. Хамаатан

Г. Нагац

8. Балархай эгшгийн үүргийг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. шударга

а. зөөлрүүлэх

2. найдвар

б. Эгшигжүүлэх

3. анги

в. Ялгах

А. 1а 2в 3б

Б. 1в 2а 3б

В. 1в 2б 3а

Г. 1в 2а 3б



4-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ.

Сурагчийн нэр .....

Б Хувилбар

НИЙТ ОНОО 24

2024.06.03

Сайхан сэтгэл

Бүргэдийн ангаахай үүрнээсээ толгойгоо цухуйлган хадан хясааны доогуур эргэлдэн нисэж байгаа олон шувууг ажиглажээ.

-Ээжээ, энэ юун олон шувуу вэ? гэж ангаахай асуув.

- Бидний анд нөхөд байна.. Бүргэд ганцаараа амьдардаг шувуу. Гэхдээ хааяа тэдэнд найз нөхөд хэрэгтэй. Тэгэхгүй бол бүргэд юуных нь шувуудын хаан байх билээ. Чиний харж байгаа бүх шувууд бидний анд нөхөд гэж ээж бүргэд ангаахайдаа хэллээ. Ээжийнхээ хэлсэн үгийг ангаахай сайтар бодоод тэднийг анд нөхдөө гэж санах болов. Тэгснээ гэнэт чарлаж:

-Хүүе, тэд нар манай хоолыг хулгайлж байна гэв.

-Тайвшир даа. Үр минь тэд биднээс юу ч хулгайлаагүй. Би тэднийг өөрөө дайлсан юм. Бүргэд өөрөө хэчнээн өлсөж байлаа ч дэргэдээ байгаа шувуутай хувааж иддэг жамтай. Ийм өндөрт байгаа шувууд хоол олж идэхэд хэцүү тул бие биеэ дэмжиж тусалдаг юм гэжээ. Үнэнч сайн нөхөдтэй байя гэж бодсон хэн ч бусдын гачигдлыг анхаарч байх хэрэгтэй юм.

1. Бүргэдийн ангаахай хэнтэй ярилцсан бэ?

А. Олон шувуудтай      Б. Дайсантайгаа      В. Ээжтэйгээ      Г. Хадан хясаатай

2. Бүргэд яагаад шувуудын хаан бэ?

А. Найз нөхөд ихтэй      Б. Хоолоо бусад шувуунд алдсан.      В. Ганцаараа амьдардаг      Г. Том биетэй

3. Уриалсан өнгө аястай үгийг олоорой.

А. Дэмжих      Б. Дэмжинэ      В. Дэмждэг      Г. Дэмжицгээе

4. “Санах” гэдэг үгийн шууд утгыг гаргасан хэсгийг олоорой.

А. Сайн санах      Б. Хорон санаа      В. Хар хоргүй      Г. Тусч сэтгэл

5. Цэгийн оронд тохирох үгийг сонгон бичиж, өгүүлбэрийг гүйцээгээрэй. Эмээ өвөөгийн үгийг .....

А. Сонсёо      Б. Сонсоё      В. Сонсьё      Г. Сонсьё

6. “Ийм өндөрт байгаа шувууд хоол олж идэхэд хэцүү тул бие биеэ дэмжиж тусалдаг юм” гэж хэний хэлсэн үг вэ?

А. Зохиогчийн үг      Б. Бүргэдийн үг      В. Ангаахайн үг      Г. Бусад шувуудын үг

7. “Хадан хясаа” - тохирох утгыг зөв сонгоорой.

А. Өндөр чулуутай уул      Б. Өндөр уулын орой      В. Бүргэдийн үүр      Г. Уу



4-р ангийн “МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Монгол хэл	Даалгаврын тоо	Хувилбар А	Хувилбар Б	Оноо	Аргачлал
	1	В	В	1	Зөв хариулт
	2	Г	А	1	Зөв хариулт
	3	Г	Г	1	Зөв хариулт
	4	В	А	1	Зөв хариулт
	5	В	Г	1	Зөв хариулт
	6	Г	Б	1	Зөв хариулт
	7	Б	А	1	Зөв хариулт
	8	В	В	1	Зөв хариулт
	9	В	Б	1	Зөв хариулт
	10	Б	А	1	Зөв хариулт
	11	Асуултын дагуу зөв бичсэн бол -2 Дөхүүлсэн санаа гаргасан бол- 1		2	
	12	А. Өдөрийн хүргье-өдрийн хүргэе Б. Зурагаа будья- зургаа будья		3	Үгээ бүрэн олсон бол- 1 оноо Зөв болгосон үг туус бүр-1 оноо
	13	А. зэмлэх-загнах, буруушаах Б. Зэмлэх- сайшаах, урамшуулах		2	Үгээ зөв олсон- 1 оноо Өгүүлбэрт зөв оруулсан бол 1 оноо
	14	Зөв олсон үг тус бүр- 1 оноо		2	
15	Хэнд хандсан Юуг уриалах Хэн уриалсан		5	Бүтэц-3 оноо Зөв бичиг-2 оноо Алдаа 0-1 бол 2 оноо Алдаа 4-6 бол 1 оноо Алдаа 2-3 бол 1.5 оноо	